

Цаасан мөнгө ба алтан баталгаа

Рэнцэнгийн Батмэнд *

*Доктор (Ph.D), профессор
Геополитик судлалын хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс
batmend1031@gmail.com*

Будрагчаагийн Даш-Ёндон

*Доктор (Sc.D), профессор
Шинжлэх Ухааны Академийн
Философийн хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
dashyondonbudragchaa@gmail.com*

Хураангуй

Бид энэхүү өгүүллээрээ цаасан мөнгө бол засгийн татвар хурааж төсвөө бүрдүүлэх хэрэгсэл байдаг ба аж ахуйн нэгж, хувь хүмүүс хөдөлмөрөөрөө олсон орлогоосоо татвар төлдөг учраас түүнийг хөдөлмөр хийгээд бараа, үйлчилгээ худалдан авахдаа хэрэглэсээр ирсэн түүхтэй. Хувь хүн, компанийн хөдөлмөрийн хөлс, ашиг орлогоос ихээн хувь хэмжээтэй татвар авдаг нь тэднийг ямагт мөнгөний гачигдал хомсдолд оруулж байдаг билээ. Тиймээс хүн амын дийлэнх нь ядуу, ядуувтар орлоготой иргэн байдаг. Цаасан мөнгө үнэ цэнгүй учраас бараа, таваарын үнийг худалдаачид хэт ашгийн төлөө асар өсгөдөг бөгөөд ихгэснээр цаасан мөнгө үнэгүйдэж өнөө үеийн инфляц гээчийг өдөөж, засгийн газраас өр төлбөрөө барагдуулах ихээн болонж нээж байна.

Нөгөө нэг асуудал бол АНУ-ын доллар олон улсын нөөц валют болсноор олон улсын худалдаанд нэг орны хяналт тогтох, зарим орны үндэсний валютын ханшийг унагах, ингэснээр эдийн засгийг нь дарамт, сүйрэлд оруулах хэрэгсэл болгож буйг үүгээр тодорхойлохыг зорив.

Түлхүүр үгс: цаасан мөнгө, алт, баталгаа, геополитик, үндэсний мөнгөн тэмдэгт

* The Corresponding author

<https://orcid.org/0009-0001-3866-9709>
<https://orcid.org/0009-0002-4306-8841>



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

Received: 29 August 2023

Accepted: 29 September 2023

Banknotes ad golden guarantee

Batmend Rentsen*

*Doctor (Ph.D), professor
Institute of Geopolitics Studies
Ulaanbaatar, Mongolia
batmend1031@gmail.com*

Dash-Yondon Budragchaa

*Doctor (Sc.D), professor
Institute of Philosophy,
Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia
dashyondonbudragchaa@gmail.com*

Abstract:

In this paper, we explain that paper money is a means of collecting government taxes and creating a budget, and since companies and individuals pay taxes on their labor income, they use it to buy labor, goods, and services. A large percentage of taxes are levied on the salaries and profits of individuals and companies, which always leads to a shortage of money. Therefore, most of the population is made up of poor and low-income citizens. Since paper money has no value, merchants raise the prices of goods and commodities for super profits, and by increasing the value of paper money, they stimulate today's inflation and open a great opportunity for the government to pay off its debts.

Another problem is that the US dollar becomes an international reserve currency that is used to control one country's international trade, to devalue some countries' national currencies and thus to pressure and destroy their economies.

Keywords: *banknotes, golden guarantee, geopolitics, national currency*

*“Алтан улсын цөмлөх гэж Амбагай хаан тунбао ** сэдсэн
Сартуул улсаас өс авах гэж Их хаан зоос цутгасан”
“Ахуйг тунбаогоор орлуулаад Ахуйт төр хоосрох бус уу?”
Сорхогтан бэх хатны хэлмэл*

I. Оршил

Дэлхий нийтийн банк санхүүгийн тогтолцоо 2008-2009 оны хямралаар нийт 60 их наяд долларын алдагдалд орсноос хойш мөнгөний бодлого, банк санхүүгийни хямрал сэхээ авч чадалгүй хямрал өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа нь улам лавширч, одоо дэлхийн санхүү эдийн засгийн хямралд хүрэх аюул нүүрлээд байгаа талаар бараг эдийн засагч бүр бичиж байна. Энд хоёр чухал нөхцөл онцгой үүрэгтэй. Нэгдүгээрт, өнөө үеийн геополитикийн гоц үзгдэл, хоёрдугаарт, “ноён” доллар хэмээх АНУ-ын валют дэлхий дахины худалдаа, эдийн засагт ноёрхох болсон зэрэг юм.

Геополитикийн учир шалтгаанаар өрнөдийн орнуудаас ОХУ, Ираны эсрэг тавьсан эдийн засгийн хоригоос үүдэн дэлхийн санхүүгийн тогтолцоо өөрчлөгдөж ам. долларын гүйлгээг эдгээр улсын хувьд хориглох болсон. Тухайлбал, энэхүү

** Тунбао – 621 оноос үжү (Хятадын эртний хүрэл зоос, НТӨ 118 он) зоосыг хэрэглээнээс халж гарч ирсэн түүнээс хөнгөн жинтэй, голдоо нүхтэй гуулин зоос (Хятад) -ны нэр. Тунбаог Юань улсын цолоор нэрлэсэн байна. Түүнийг хэлхээд бүс болгон авч явахад аюулгүй байжээ. Тийм бүсийг Раньчань буюу “замын зардал” гэдэг байсан бөгөөд монголоор “янчаан” болон сунжирч хэрэглэгддэг болсон аж.

хоригийн улмаас ОХУ ам. доллараар төлбөр тооцоо хийх аргагүйд хүрч өөр арга зам хайж байна. Жишээдбэл, харилцагч орнуудтай үндэсний мөнгөн тэмдэгтээр харилцан төлбөр хийх, БРИКС, ШХАБ мэтийн холбоотон улсуудын дунд нийтлэг шинэ мөнгөн тэмдэгт (шилжих рубль шиг) гаргах, төлбөр тооцооны шинэ тогтолцоо сэдэх хандлагатай боллоо. Ялангуяа, ОХУ болон Хятадын хооронд үндэсний мөнгөн тэмдэгтээр (рубль, юань) төлбөр тооцоо хийж эхлэв. Дээр нь ОХУ нөхөрсөг бус орнуудад эрчим хүчний эх үүсвэрийг зөвхөн рублиэр худалдах шийдвэр гаргасан нь түүний ач холбогдлыг ихээхэн өргөв. Түүнчлэн БНХАУ-ын дарга Ши Жинпинь Саудийн Арабад айлчилж Шанхайн биржийн үнээр газрын тос худалдан авах тухай 25 жилийн гэрээ хийж төлбөрийг юаниар (369 тэрбум доллар) хийхээр тохирч байгаа нь одоогоор цорын ганц тогтвортой нөөц валют болж буй ам.долларын давуурхал нэгэн цагт үгүй болж болох хандлага гарч, энэ нь бага орнуудын эдийн засагт ихээхэн дарамт учруулах хандлагатай боллоо.

Түүний зэрэгцээ шинээр үүсэх валюттай үндэсний хөнгөн тэмдэгт хэрхэн харьцах, ямар ханштай байх нь эргэлзээтэй боллоо. Манай орны хувьд гадаад худалдааг зөвхөн ам. доллартай уяж байгаагаас түүний төгрөгтэй харьцах ханшын өсөлт улам нэмэгдэж, инфляцийн гол шалтгаан болж, улсын өр, төлбөр тооцоонд томоохон хүндрэл учруулж байна. Тийм учраас цаасан мөнгө “төгрөг”-ийг үнэт метал болон бусад хөрөнгийн баталгаатай болгох замаар түүний ханш, хөрвөх чадварыг өсгөх, тогтвортой болгох нь манай эдийн засагт нэн тулгамдсан асуудал болоод байна.

II. Хэлэлцүүлэг

Цаасан (fiat) мөнгө. Монголчууд Хүннү, Түрэг, Уйгурын үеэс зоосон мөнгө цутган, арилжаа наймаанд хэрэглэж, 1227 онд дэлхийд анх удаа цаасан мөнгө хэвлүүлж гүйлгээнд ашиглаж асан эртний түүхтэй улс юм. Цаасан мөнгө хамгийн анх Хятадын Сычуаньд (1023) үүссэн гэж түүхэнд тэмдэглэгдсэн бөгөөд Жяозы буюу “мөнгөний баримт” [2] гэсэн утгатай байж. Европын анханы цаасан мөнгийг Шведэд 1661 онд гаргаснаас хойш 350 гаруй жил дэлхийн бүх улсын санхүүгийн тогтолцоонд бат бэх суурьшсан ажээ. Орчин цагт цаасан мөнгөийг олон улсад “fiat” хэмээх латин үгээр илэрхийлдэг бөгөөд англи хэлээр “let it be done” буюу монгол хэлнээ “хийхтүн” гэсэн шуу орчуулагдах хиймэл, зохиомол цаасан мөнгө гэсэн утгатай юм. Тэгээд үүнийг олон улсын практикт цаасан мөнгө (paper money) хэмээн нэрлэх болжээ. Цаасан мөнгө өөртөө хэрэглээний ямар ч өртөг (үнэ цэн) агуулахгүй. Харин цаасан мөнгийг зөвхөн засгийн газраас үнэ цэнтэй буюу өртөгтэй болгож байвал сая өртгийн илэрхийлэл болно [6]. Жаозы хэмээн нэрлэгдэж байсан анханы цаасан мөнгө тусгай пүүст хадгалуулсан зоосон мөнгийг илэрхийлдэг байсан бол одооны цаасан мөнгө ямар нэгэн бараа таваар, үнэт метал (алт)-ын баталгаагүй. Тийм учраас үндэсний мөнгөн тэмдэгт валют (олон улсын солилцооны хэрэгсэл) болж хөрвөх чадваргүй юм.

Цаасан мөнгө нь алт, мөнгө зэрэг үнэт метал мэт үндэсний үнэт эрднэсийн сан хөмрөгтэй холбоогүй учраас бараа таваарын үнийн өсөлт буюу инфляцид өртөх, түүгээрч барахгүй үнийн хэт өсөлт-гипер инфляцийн улмаас ямар ч үнэгүй цаас болох эрсдэлтэй (жишээ нь: Дэлхийн II дайны дараахь унгарын форинт,

германы марк г.м.) юм. Хүмүүсийн үндэсний цаасан мөнгөнд итгэх итгэл алдарсны улмаас үнэ цэнээ бүрмөсөн алдаж болно (Жишээ нь: Компучийн улаан хкемерийн ялагдлын дараахи үеийн цаасан мөнгө). Цаасан мөнгө алт, мөнгө зэрэг үнэт металаар баталгаажсан үндэсний мөнгөн тэмдэгтээс эрс ялгаатай болгодог бөгөөд баталгаатай мөнгөн тэмдэгт бол дотоод өртөг (үнэ цэн) агуулж байдаг. Харин төр засгаас хууль ёсны төлбөрийн хэрэгсэл болгох шийдвэр, тогтоол гаргасан тохиолдолд цаасан мөнгө үндэсний мөнгөн тэмдэгт болдог байна. Тиймээс Засаг сонгуулиар өөрчлөгддөг нь түүнийг эрсдэлтэй болгодог билээ. Үүний нэг жишээ бол АНУ-ын доллар бөгөөд түүнийг хувийн компани эзэмшдэг ч, харин, Америкийн Сангийн яам түүний ашиглахаар худалдан авах гэрээ хийснээр «үнэ цэнтэй» болж, төлбөрийн хэрэгсэлийн үүрэг гүйцэтгэнэ.

Ер нь цаасан мөнгө бол засгийн татвар хурааж төсвөө бүрдүүлэх хэрэгсэл байдаг ба аж ахуйн нэгж, хувь хүмүүс хөдөлмөрөөрөө олсон орлогоосоо татвар төлдөг учраас түүнийг хөдөлмөр хийгээд бараа, үйлчилгээ худалдан авахдаа хэрэглэсээр иржээ. Хувь хүн, компанийн хөдөлмөрийн хөлс, ашиг орлогоос ихээхн хувь хэмжээтэй татвар авдаг нь тэднийг ямагт мөнгөний гачигдал хомсдолд оруулж байдаг билээ. Тиймээс хүн амын дийлэнх нь ядуу, ядуувтар орлоготой иргэн байдаг. Цаасан мөнгө үнэ цэнгүй учраас бараа, таваарын үнийг худалдаачид хэт ашгийн төлөө асар өсгөдөг бөгөөд ихгэснээр цаасан мөнгө үнэгүйдэж өнөө үеийн инфляц гээчийг өдөөж, засгийн газраас өр төлбөрөө барагдуулах ихээхэн боломж нээж байна. Нөгөө нэг асуудал бол АНУ-ын доллар олон улсын нөөц валют болсноор олон улсын худалдаанд нэг орны хяналт тогтох, зарим орны үндэсний валютын ханшийг унагах, ингэснээр эдийн засгийг нь дарамт, сүйрэлд оруулах хэрэгсэл болгож байна.

Олон улсын нөөц валют – АНУ-ын доллар. Олон улсын нөөц валют гэж олон улсад худалдааны мөнгөн гүйлгээ хийхэд ашиглах зорилготойгоор улс орны төв банк болон санхүүгийн байгууллагуудад хадгалагдаж байдаг ихээхэн хэмжээтэй цаасан валютыг хэлдэг. Нөөц валют нь улс орнууд худалдаа хийхийн тулд үндэсний валютаа сольж ханшийн алдагдалд орох эрсдлийг бууруулна гэж үздэг. Нөөц валютыг мөнгөний нийт эргэлтэнд оруулахгүйгээр төв банк хадгалж, түүнийг улс орны бараа таваарын худалдааг үндэснийхээс өөр валютаар хийсний үндсэнд бий болгодог аж.

АНУ-ын доллар 60 гаруй жилийн турш дэлхийн анхан шатны нөөц валют болсоор ирэв. Ийм эрхэм дээд өргөмжлөл 1943 онд Тегранд эхлэж Ялтад төгсгөл болсон гэж үздэг. Энэ үеэр дэлхийн нөөц валют бий болгож, түүнийг АНУ хангаж байх тухай асуудлыг АНУ хөндөхөд “коммунизм багуулах учир тэнд мөнгө, түүний дотор нөөц валютын хэрэгцээ байхгүй, тэд коммунизмыг дөгөлөх гэж байна” гэж Сталин өөрөө үзээд хэрэгсэхгүй орхисон билээ. Гэтэл 1944 онд Бреттон Вудсийн хэлэлцээрээр АНУ-ын долларыг олон улсын нөөц валютаар сонгожээ. Энэхүү тогтолцоогоор долларыг алттай, харин бусад улсын мөнгөн тэмдэгтийг доллартай уяхаар шийдвэрлэсэн билээ. Энэ үед ам. доллар дэлхийн мөнгөний нөөцөд хоёрт ордог валют байлаа.

Холбооны нөөцийн сан зээлийн хүүгийн хувь хэмжээг үргэлж нэмэгдүүлж, эсхүл бууруулж байдаг нь АНУ-ын эдийн засаг бусад оруудынхыг бодвол илүү

эрүүл гэж үзэхэд хүргэдэг учраас долларын ханш чанга байдаг. Гэвч чанга доллар АНУ-ын олон улсын хэмжээнд ажилладаг компаниудын үнэт цаасыг үнэгүүлдүүлж, харин АНУ-д экспорт хийдэг компаниудын үнэт цаасыг дэмждэг гэж үздэг.

Ш. Судалгааны үр дүн

Хэдийгээр ам.доллар хөөц валютынхаа хувьд хэзээ магадгүй өөр нөөц валютад байраа тавьж өгөх нь магадлал багатай ч ногоон мөнгөнөөс гэнэт татгалзах нь нөөц валютын төлбөр тооцоо доллар, евро, юанийн хооронд хуваарилагдан дэлхийн эдийн засгийг илүү хэсэг бусад болгон бутаргах болно. Ингэх нь АНУ-ын хувьд үхлийн аюултай учраас доллар хэмээх валютын дайн явж байна. Ийм оролдлогыг хүчирхэгжиж байгаа орнууд хийсээр байгаагаас үзвэл нөөц валют болохын хувьд доллар ганхаж гадаад худалдаа өөр валютад суурилдаг болох нь цаг хугацааны л асуудал болоод байна. Ам.доллар нөөц валютын хувьд сүйрч болох хэд хэдэн нөхцөл бүрэлдээд байна.

Нэгдүгээрт, дэлхий нийтийн геополитикийн мөргөлдөөн нутаг дэвсгэр, бүс нутгийн дайнаас хальж улс хооронд (Украин-ОХУ хооронд)-ын шинжтэй болж, цаашлаад, европын холбоо, НАТО, түүгээрч барахгүй АНУ-ыг татан оролцуулж болзошгүй байгаа нь дэлхийн дайн болон хувирч нийт эдийн засгийн хямралыг лавшруулан сүйрэлд дуудаж болохоор байна.

Хоёрдугаарт, олон улсын санхүүгийн хуурамч үйлдлээр аль эрт эхэлсэн “санхүүгийн дайн” дэлхийн санхүүгийн зах зээлд эмх замбараагүй байдал авч ирлээ. Санхүүгийн дайнд эсрэг талынхаа эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагааг хорлон сүйтгэхийн тулд үүсмэл хөрөнгө (derivative-үнэт цаас) хэрэглэх, валютын ханшид зориудаар нөлөөлөх замаар дайсан этгээдийнхээ дунд үймээн самуун дэгдээх, хэрэглэгчдийн итгэлийг алдагдуулах үйлдэл хийж байна. Санхүүгийн дайны хэрэгсэлд нууц тусламж хамгаалалтын сан (hedge fund) байгуулах, цахим довтолгоон (cyberattack) хийх асуудал бас багтдаг. Санхүүгийн дайн бол өөрийн баялагийг дээд зэргээр нэмэгдүүлэх арга биш дайснаа ялж дийлэх, устгах зорилготой байдаг. Ялангуяа, ам.долларын ноёрхол тогтсон өнөө үед АНУ дэлхийн зах зээл дээр өөрийнхөө эдийн засгийн аюулгүй байдлын төлөө ажилладаг улс гүрнүүдтэй хэзээ ч зэрэгцэн оршихыг хүсэхгүй тул санхүүгийн дайны эрсдэл асар их байна.

Гуравдугаарт, инфляц бол хуримтлал, хөрөнгө, эдийн засгийн өсөлтийн эвдэн бусниулдаг үл үзэгдэгч хэрэгсэл юм. Энэ нь эдийн засгийн амьдралд түүнийг таниж мэдэх, ойлгохоос өмнө аль эрт эхэлчсэн байдаг бөгөөд төв банкуудад нэн чухал ойлголт боловч тэд хоцрох буюу мөнгөний төөрөгдөлд орох нь хялбар байна. Яг одоо бидний амьдарч байгаа энэ мөчид дэлхийн улс орнуудын үнийн өсөлт буюу инфляц хоёр оронтойгоос гурван оронтой тоонд багтаж байна. Цалин хөлс нэмэгдүүлэхийг шаардсан нийтийн хөдөлгөөн дэлхий даяар өрнөж байна.

Дөрөвдүгээрт, зах зээлийн сүйрэл болж байна. Өнгөрсөн хоёр жилд дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас олон улсын худалдаа, тэврийн гинжин хэлхээ тасарч нийлүүлэлт тасалдав. Өрнөдийн орнуудаас ОХУ-ын эсрэг авсан эдийн засгийн хориг эрчим хүний эх үүсвэрийн үнийг ихээхэн өсгөж, нийлүүлэлтийг тасалдууллаа. Зах зээлийн сүйрэлд банкны тохируулах чадвар сул, тэдний шунал тачаал хэрээс хэтэрсэн нь нэмэр болж байна. Бас бүх төв банк мөнгө хэвлэж зах

зээлд шахахаас өөр эрдэмгүй болсон байна. Зарим шинжээчдийн үнэлгээгээр зах зээл дээрхи үүсмэл хөрөнгийн хэмжээ дэлхийн нийт ДНБ-ний хэмжээнээс арав дахин их хэмжээтэй болсон хэмээн үнэлж байгаа нь сүйрлийг улам түргэсгэж байна. Зах зээлийн асар их нарийн нийлмэл тогтолцоог үнэлэх чадвар ч байхгүй боллоо.

Тавдугаарт, сүйрэл ар араасаа нэмэгдэж байна. АНУ цэрэг, дайны ажиллагааг санхүүжүүлэхийн тулд доллар хэвлэгч 12 компани жилийн дөрвөн улиралд 24 цагаар ажилуулж байгаа нь түүний нийлүүлэлт дэлхий дахинаа хэтэрхий ихдэх хандлагатай байна. Дийлэнх томоохон улсууд валютын нөөцөө АНУ-ын үнэт цаасаар (treasury bond) бүрдүүлсэн нь бондын зах зээл дээр асар их хэмжээний долларын хэрэгцээ үүсч түүний ханш гэнэт унаж болохоор байна. Эцсийн эцэст улс орнууд гаднын дайралтаас бус санхүүгийн дотоод замбараагүйлгээс үүдэн санхүүгийн тогтолцоо нь өөрөө нурах хандлага ч ажиглагдаж байна.

Энэ бүхнээс авч үзвэл дэлхийн худалдаа, эдийн засгийн өөр туйлууд (БНХАУ, ОХУ, Энэтхэг, газрын тос үйлдвэрлэгч орнуудыг багтаасан) үүсэх магадлал өндөр байна. Энэ бүхэн үндэсний мөнгөн тэмдэгтийг ихээхэн сулруулж болохыг шинжээчид анхааруулсаар байна. Тэгвэл бид юунд бэлтгэж, юу хийх ёстой вэ?

Алтан баталгаа. Цаасан мөнгө алтан баталгаатай явж ирсэн өмнөх үеүүдэд үнийн өсөлт гэж бараг байдаггүй, ханш тогтвортой байсны дээр ямар ч мөнгөн тэмдэгтийг алтаар сольж болдог байсан учраас цаасан мөнгөнд итгэх итгэл өндөр, дэлхийн худалдаа тогтвортой байв. Үйлдвэрлэгч, худалдаач нар “бурхан”-д бус “алтан”-д итгэж байв. Олон улсын худалдаа эрчимтэй хөгжихийн хамт XIX зууны хоёрдугаар хагасаас ихэнх оронд «алтан стандарт»-ын тогтолцоо буй болсон бөгөөд энэ үеэс улс орнуудын валютын ханш ба өртөг нь алтны тоон агуулгаар тодорхойлогдох болсон байна. Энэ үед валютын арилжаа эрхэлдэг газрууд буюу улсын банкууд цаасан мөнгийг алтан агуулгынх нь дагуу зохих алтаар чөлөөтэй сольж байв. Нөгөө талд банкууд олон улсын зах зээлээс алтыг чөлөөтэй худалдан авч байжээ. Жишээлбэл: Их Британид 1 фунт стерлингийн алтны цэвэр агуулга 1821 оноос 7.322385 гр, германы 1 марк 1873 оноос 0.385422 гр. алттай тэнцэж байв. Иймд фунт стерлингийн валютын ханш марктай 1:20.43 гэсэн харьцаагаар тодорхойлогдож байв. Үндэсний валют дахь алтан агуулгын энэ тогтолцоо 1914 он хүртэл өөрчлөгдөөгүй явж ирсэн юм. Энэ үед эдийн засаг дахь төрийн оролцоо бага байсан байна. Тиймээс 1880-1913 онд «алтан стандарт»-ын тогтолцоо төрийн зүгээс өөрийн зардлыг ханшны уналтаар санхүүжүүлэх боломж олгодоггүй байсан учраас улс орнуудад бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдан өссөн байна.

Алт бол бүх металаас онцгой шинжтэй. Энэ метал зэвэрдэггүй, бараг исэлддэггүй, хаан давсаас бусад юунд ч уусдаггүй, соронзон үйлчилгээнд автдаггүй, хорт цацраг ялгаруулдаггүй, байгальд цэвэрээрээ бараг оршдоггүй, нилээд ховорт тооцогддог билээ. Ийм учраас түүнийг хүн төрөлхтөн мөнгө болон түүний жишиг болгон хэдн мянган жилээр ашигласаар ирсэн юм. Тэгэхлээр, алт бол мөнгө, түүнд суурилсан мөнгөний стандарт байх боломжтой бөгөөд байх ч ёстой гэдгийг судлаачид нотолсоор байна [6]. Хэрвээ алтны албан ёсны стандарт байхгүй бол хувь хүн өөрийнхөө эд баялагийг хамгаалахын тулд алт худалдан авч цаасан мөнгийг үнэгүйдүүлдэг баримт захаас аван олдох билээ. Энэ нь үнийн

өсөлтийг хөөрөгдөж давруулахаас эхлээд гипер хүртлэх инфляцийг өдөөдөг нь практикт илэрхий. Алтаар баталгаажсан мөнгийг хуурмчаар үйлдэх, завхруулахад хялбар бус. Харин цаасан мөнгийг ямарч хэлбэрээр завхруулж болдгийг бид харсаар байна. Цаасан мөнгө итгэлд суурилдаг бол алт өөрөө өртөгтөй, үнэ цэнтэй байдаг. Цаасан мөнгийг хязгааргүй хэмжээгээр хэвлэж засгийн өрийг нэмэгдүүлдэг цаасан мөнгөний далд урсгалаар террор, дайн самууныг санхүүжүүлж, инфляцыг жолоодлогогүй болгодгийг бид харсаар байна. Төв банкууд түүнийг яаж ч онилоод дийлэхгүй байгаагаар үл барам ядуурал, өлсгөлөнгийн шалтгаан болж байна. Дээр нь, олон улсын нөөц валютын нэг ам.долларын ханшийг зохиомлоор хөшүүрэгдэж үндэсний мөнгөн тэмдэгтийн хөвөгч ханшийг (floating exchange rate) бууруулж инфляцад нөлөөж байгаа бол одоо олон улсын худалдаа, эдийн засгийн хоригын зэвсэг болоод байна.

Алтан баталгаанаас хагацах замыг Милтон Фриедман тавьсан юм. Гэвч дэлхий дахины банк, санхүүгийн тогтолцооны хэд хэдэн сүйрэл, зах зээлийн эдийн засгийн хямрал болоход цаасан мөнгө, банк санхүүгийн байгууллагын оролцоо үндсэн үүрэг гүйцэтгэв. Үүнийг сөрсөн орнууд өөрсдийн үндэсний мөнгөн тэмдэгтийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд түүнийг алтан баталгаатай болгохын төлөө ажиллаж байна.

Ер нь алт бол мөнгө учраас түүнийг Төв банк цаасан мөнгөний нэгэн адил хариуцаж, тайлан тэнцэлдээ авч байдаг. Хэдийгээр, алтыг цаасан мөнгөний жишиг болгоогүй ч ханшийг нь алтны үнэтэй жишиж тогтоодог байна. Тухайлбал, 1 унц алтны үнэ өсч байвал ам. долларын ханш унаж, түүний үнэ буурч байвал доллар чангарч байдаг билээ.


Алтан баталгаатай мөнгөн (цаасан) дэвсгэрт гүйлгээнд байсан сонгодог алтан стандартын үе дэлхийн I дайн эхэлснээр 1914 онд төгсгөл болж, алтан баталгаагүй мөнгөн дэвсгэрт гүйлгээнд их хэмжээгээр зонхилох болж, дэлхийн эдийн засагт гүн хямрал гаргах шинж тэмдэг мэдрэгдэж эхэлсэн байна. Дараа нь бас АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсоны инфляцийн өсөлттэй холбогдуулан 1971 онд авч хэрэгжүүлсэн эдийн засгийн цуврал арга хэмжээний нэг нь долларын алтан стандартыг халсан явдал бөгөөд хамгийн чухал нь цалин, үнийг царцаах, импортын нэмэлт хураамж авах болж, олон улсын мөнгөн тэмдэгт долларт шууд хөрвөх чадварыг дангаар цуцалсан явдал байв.

Хэдийгээр Никсоны үйлдлүүд одоо байгаа олон улсын санхүүгийн солилцооны Бреттон Вудсын системийг албан ёсоор устгаагүй ч түүний гол бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгийг зогсоосноор Бреттон Вудсын системийг үр дүнтэйгээр хүчингүй болгосон. Ричард Никсон Бреттон Вудсын системийн шинэчлэлийг хэрэгжүүлсний дараа ам.долларын шууд хөрвөх чадварыг сэргээх бодолтой байгаагаар олон нийтэд мэдэгдсэн ч шинэчлэл хийх бүх оролдлого амжилтгүй болсон билээ. Бреттон Вудсын системийг чөлөөтэй хөвөгч валют дээр суурилсан одоогийн дэглэмээр 1973 он гэхэд де факто сольсон юм.

Гэвч, алтны үнийн өсөлтийг хүчээр унагаж ам. долларын ханшийг барьж байдаг нь хэн бүхний мэдээжийн хэрэг. Тэглээч, тухайн үндэсний мөнгөн тэмдэгтийн хүч чадал түүний алтны албан нөөцөөс, тухайлбал, алтны нөөц, ДНБ-ний харьцаанаас ихээхэн хамааралтай байдаг нь дараахь жишээнээс харагдана. Өнөөнийн байдлаар

АНУ 8133 тонн, Герман 3359, Итали 2251, Франц 2436, ОХУ 2299, Хятад 1948, Швецарь 1040, Япон 846 тонн алтны нөөцөөрөө тэргүүлж хамгийн их нөөцтөй 10 орны тоонд орж байна. Монгол Улсын алтны албан нөөц 2020 оны байдлаар 9,5 тонн (Дэлхийн банкны статистик) байна. Дэлхийн бараг бүх орон мөнгөжсөн алт худалдан авч, гадагш худалдахыг хориглож байхад Монгол улс олборлосон алтаа цэвэршүүлж (99.99%) валютын нөөцөө нэмэгдүүлэхийн оронд түр зуурын ашгийн бодон бүгдийг нь экспортлож худалддаг. Монгол Улсын байгаль дахь алтны батлагдсан нөөцийг 3000 тонн гэж үздэг байна. Үүнээс харвал манай эдийн засаг хангалттай хүч чадалтай байх боломжтой юм. Харин Швецарийн алт цэвэршүүлэх үйлдвэр хоногийн 24 цагт гурван ээлжээр ажиллан 20 тонн алт цэвэршүүлдэг байна. Түүний дийлэнхийг БНХАУ худалдан авдаг ажээ. Дэлхийн алтны зөвлөлийн мэдээлж байгаагаас харвал дэлхийн янз бүрийн орнуудын төв банк зөвхөн 2022 оны 9 дүгээр сард 400 тонн үнэт метал худалдан авсан байна. Ялангуяа, өрнөдийн орнууд ОХУ-ын төв банкны 300 тэрбум ам.долларын хэмжээтэй гадаад валютын нөөцийг царцааж, түүнийг украйнд шилжүүлэн өгөх тухай яригдах болсноос хойш ам.доллар, евро, тэдгээрээр үнэлэгдэх үнэт цаасанд итгэл алдарч, алтан гулдмай худалдан авах үйл ажиллагаа идэвхжиж байна (Bloomberg). Алтан гулдмайд байдаг нэг онцлог бол бондыг бодвол итгэл үл даах харилцагчтай холбогдох шаардлагагүй байдагт оршино.


Зураг 1. Төгрөгийн ханшийн өөрчлөлт, \$1 долларын эсрэг



Эх сурвалж: mongolbank.mn

Монгол Улсын банкны мөнгөн тэмдэгт баталгаагүй байдаг нь ам.долларын ханш унаж байсан ч эсрэгээр төгрөгийн ханш өсч байдаг гажиг тогтолцоотой юм. Үүнээс үүдэн ам.доллараар худалдан авсан бараа, үйлчилгээгээр дамжин тус улсад үнийн өсөлт авчирдаг. Бидний хийсэн судалгаанаас харвал 1993 оны ам.долларын эсрэг төгрөгийн ханш 150 байсныг 2023 оныхтой харьцуулбал даруй 23 дахин нэмэгдсэн байна. Тухайлбал, 2013 оноос 2023 оныг хүртэл жил бүр 123-125 хувиар өсч иржээ. График 1-ийг харна уу?

Зураг 2. Инцляц



Эх сурвалж: mongolbank.mn

Үүнийг дагаад бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ нэмэгдэж иргэдийн амьдралд хүнд дарамт учруулж байна. График 2-оос харвал инфляц ерөнхийдөө буурах хандлагатай байгаа хэдий ч дундчаар хоёр оронтой тоогоор өссөн хэвээр байгаа нь тус улсын эдийн засгийн хүч чадлыг суларуулах үндсийн нэг болж байна. Үүний дээр төгрөгийн худалдан авах чадвар маш сул байна (Дэлхийн 144 орноос сүүлчээсээ 14 дүгээр байранд ордог). Энэ бүхнээс үзвэл төгрөгийн гадаад валютын эсрэг ханшийг чангаруулж дотоодын инфляцийг бууруулах,

IV. Дүгнэлт

Төгрөгийг алтан баталгаатай болгох шаардлага:

1. Дэлхийн эдийн засаг, санхүү, банкны хямрал гүнзгийрч цаашид сүйрлийн түвшинд хүрч болох хандлагатай боллоо. Ялангуяа, олон улсын төлбөр тооцоонд олон туйлт санхүүгийн тогтолцоо бүрэлдэж байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд хүрч байна.
2. Өрнөдийн орнуудаас үзүүлж байгаа эдийн засгийн хоригоос үүдэн манай хөрш орнууд хоорондын төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийж, БРИКС болон ШХАБ-ын хүрээнд шинэ нөөц валют бий болгох талаар эрэл хайгуул хийж эхлэсэн нь манай гадаад төлбөр тооцоонд шинэ нөхцөл бий болгож магадгүй байна. Энэ нь манай гадаад худалдааны гол түншүүдийг хамарч байна.
3. Манай банк, санхүүгийн байгууллагууд сонгодог банкны хэлбэрээс гажиж ашиг, орлого, давхар бизнесийн үр өгөөжийн төлөө ажиллаж, үүсмэл хөрөнгө (derivative)-ийн боол болж байгаа нь төгрөгийн ам.доллар болж хөрвөх, худалдан авах чадварыг үгүй хийж байна.
4. Төгрөг худалдан авах, ам.долларын эсрэг хөрвөх чадвар султайн улмаас

цалин, тэтгэвэр, хуримтлалыг үнэгүүдүүлж ядуурал, баян хоосны ялгаа, сэтгэл санааны болон нийгмийн дарамтыг улам нэмэгдүүлж байна.

5. Манай мөнгөн тэмдэгт төгрөг нь бүх валютын эсрэг сул байгаа учраас манай ажиллах хүчин гадагш урсаж, дотооддоо ажиллах хүчний хомсдолд орж байгаагийн дээр ажилгүйдэл, инфляц, авлигын эх булаг болж, улсын өөрийн түвшнийг зохистой хэмжээнээс хэт дээгүүр болгож байна.
6. Өмнөд дурсан болон бусад олон хүчин зүйлийн улмаас төгрөгийн худалдан авах, бусад валютын эсрэг хөрвөх чадварыг дээшлүүлэх нэн чухал зорилт тавигдаж байна.
7. Юуны өмнө мөнгөжсөн алтны нөөцийг ДНБ-ээс 5-6 дахин их байх хэмжээнд хүртэл өсгөх хэрэгтэй боллоо.
8. Нөөц валютын сагсыг ам.доллар, евро, иенийн бүтэцтэйгээр тооцож дундач ханш тогтоох, харин рубль, юанийн хувьд шууд үндэсний валютаар худалдаа хийх зарчимд шилжих шаардлагатай болж байна. Үүний тулд төгрөгийг алттай уяж өгөх ёстой болно.
9. Үндэсний мөнгөн тэмдэгтийн шинэтгэл хийж бага мөнгөний онол баримталснаар төгрөгийн үнэ цэнийг эрс өргөж, нийт валютын эсрэг хөрвөх чадварыг сайжуулна.
10. Эдгээр асуудлыг шидвэрлэхгүйгээр тус улсын эдийн засийг аюулгүй байдал, түүний хөгжлийг хангахад томоохон бэрхшээл учирсан хэвээр байх болно.
11. Банк, санхүү, мөнгө зээлийн хуучин тогтолцоог сайжруулах гэж хүч хөрөнгө, цаг хугацаа хий дэмий зарцуулахын оронд биднийг угтан ирэх шинэ тогтолцоонд одооноос бэлтгэж, түүнийг бий болгох хэрэгтэй байна.

Ашигласан материал

Журнайн Нүрээд, Хөх Монголыг төрөөр бадраах хугагтай нэурит засаг-ийн алтан дээд үнэний аялгуу, 1-р дэвтэр, Монгол Улс, 2000

Хятадын соёлын мэдлэгийн толь, “Феникс” хэвлэлийн газар, Улаанбаатар, 2022

Mervin King, The end of alchemy: Money, Banking and the Future of the Global Economy, London, 2016.

Alan Greenspan, The Age of Turbulence, Penguin Books, 2008.

James Rickards, History of Money, New York, 1997.

James Rickards, The death of Money: The coming collapse of the international monetary system, Portfolio/Penguin, 2014.

James Rickards, The new case for gold, Portfolio/Penguin, 2016.

Инфляц, үнийн өөрчлөл, Жилийн танилцуулга, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, 2019